



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙГАА БОЛОВСОН
ХҮЧНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



19 сумын 112 багт
117089 хүн ам



49.7%



50.3%



аймгийн төвд 33.5%
сумын төвд 22.8%
хөдөө 46.7%



аймгийн төв Арвайхээр
суманд 10000 гаруй
өрхөд 35725 хүн




2023 онд шилжиж ирсэн хүн 1071
16-гаас доош насны хүүхэд 481
насанд хүрэгч 590






ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Өвөрхангай аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа-г 2023 онд МУИС-ийн Социологийн Боловсрол төвөөр хийлгэсэн.



■ хөдөлмөрийн насны хүн ам ■ нийт хүн ам



■ ажил эрхэлж буй хүн ■ хөдөлмөрийн насны нийт хүн




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ажиллах хүчний оролцооны түвшин 71.4 хувь болж, өмнөх оноос 3.2 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлтээс харахад хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 71 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байна. Энэхүү өсөлт нь улсын дунджаас 12.8 пунктээр, хангайн бүсийн дунджаас 5.3 пунктээр их байгаа нь орон нутгийн түвшинд бий болсон эдийн засгийн хөгжлийн өсөлт дээр тулгуурлан хөдөлмөрийн зах зээлийг тэлэх таатай боломж байна гэж үзэж байна.



Ажиллах хүчний оролцооны түвшин






ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ



Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Өвөрхангай аймгийн ажилгүйдлийн түвшин дунджаар 5.7 байсан ба 2014-2015 онд хамгийн бага хэмжээнд хүрсэн нь 3.5 болжээ. 2023 онд өмнөх онтой харьцуулахад ажилгүйдлийн түвшин 2.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны байдлаар нийт төрийн албан хаагчдын 75.4 хувь нь эмэгтэй, 24.5 хувь нь эрэгтэй албан хаагч байгаа бол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 684 хүн ажил хайж бүртгүүлсний 57.9 хувь нь эмэгтэй хүмүүс байна. Иймд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар орон нутгийн түвшинд бодлого боловсруулан эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ажилд орохоор бүртгүүлсэн иргэд






ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ




Аймгийн хэмжээнд 1680 шинэ ажлын байр бий болсон нь өмнөх оноос 28.7 хувиар буюу 375 ажлын байраар нэмэгдсэн байна. Нийт ажлын байрны 41.8 хувь нь Арвайхээр, 22.1 хувь нь Хархорин, 11.5 хувь нь Бат-Өлзий, 10.6 хувь нь Хужирт, 8.2 хувь нь Уянга, 5.8 хувь нь Богд суманд тус тус бий болсон байна.

Шинээр бий болсон ажлын байр (тоогоор)



2023 онд сумдад шинээр бий болсон ажлын байр (хувиар)





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ



2023 оны байдлаар аймгийн бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж **2473** байна.



Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 1076 аж ахуйн нэгж байна.




Ажиллах хүч, хүний нөөцийн хувьд 73.3 хувь нь 1-9, 11.7 хувь нь 10-19, 10.6 хувь нь 20-49, 4.4 хувь нь 50-иас дээш ажилтантай байна.



Сүүлийн 10 жилд аймгийн хөдөлмөрийн зах зээлд ажиглагдаж буй ахиц дэвшил бол бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч байгаа явдал юм.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ



1 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ирсэн ажлын байрны захиалгыг сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээр тооцоход 1920 байжээ. Ажлын байрны захиалгад ажилд зуучилсан иргэдийг харьцуулбал 2014 онд 66 хувь, 2016 онд 78 хувь, 2015 онд 86.5 хувь, бусад онд 90 гаруй хувьтай байсан байна.

2 Ажилд зуучлалыг эдийн засгийн салбараар авч үзвэл 18 хувь нь ХАА-н салбарт, 18 хувь нь боловсруулах үйлдвэрлэлд, 10.6 хувь нь барилгын салбарт зуучлагдсан байна. Энэ нь орон нутагт ноос боловсруулах, махны томоохон үйлдвэрлэл бий болсонтой холбоотой ажилд зуучлал өссөн болохыг илтгэж байна.

3 Аймгийн хэмжээнд 200 гаруй төсөвт байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2024-2026 онд 150 орчим байгууллагаас ажилтнууд тэтгэвэрт гарснаар 450 гаруй сул ажлын байр бий болж, эдгээр байгууллагуудад инженер, нарийн мэргэжлийн эмч, малын эмчийн ажлын байр эрэлт ихтэй байна.

4 Аймгийн хэмжээнд 2026 он хүртэл улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 70 орчим томоохон төсөл, арга хэмжээг аймаг, сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр хөрөнгө оруулалтын үр дүнд хамгийн багаар тооцоход эрүүл мэндийн салбарт 85, боловсролын салбарт 50 гаруй ажлын байр шинээр бий болох төлөвтэй байна.




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ




Судалгааны үр дүнгээс харахад 2024 онд 1520, 2025 онд 1150, 2026 онд 1230 нийт 3900 орчим ажиллах хүчний эрэлт үүсэх төлөвтэй байна. Нийт эрэлтийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл мэргэжилтэн буюу дээд боловсролоор олгогддог мэргэжил шаардах 30.6 хувь, мэргэжил шаардахгүй 30.4 хувь, техникийн болон туслах мэргэжилтэн 39.0 орчим хувьтай байна. Ажиллах хүчний эрэлтийн 60.9 хувь нь байнгын, 36.1 хувь нь улирлын, 3.0 хувь нь түр ажлын байр тус тус байна.


Ажиллах хүчний эрэлт



Эрэлтийг ажил мэргэжлээр авч үзвэл



Ажлын байрны эрэлтийн онцлог





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ СУЛ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)



**БОЛОВСРОЛЫН
САЛБАРТ**
(61 сул ажлын байр)



Бага ангийн багш 5
Монгол хэл, уран зохиолын багш 2
Орос хэлний багш 5
Англи хэлний багш 3
Орос, англи хэлний багш 3
Математикийн багш 4
Математик, мэдээлэл зүйн багш 3
Математик, физикийн багш 1
Физикийн багш 3
Химийн багш 6
Түүх, нийгмийн ухааны багш 1

Түүх, газар зүйн багш 2
Биеийн тамирын багш 2
Дуу хөгжмийн багш 4
Зураг, технологийн багш 3
Технологийн багш 5
Сэтгэл зүйч 2
Нийгмийн ажилтан 1
Эмч 3
Бичиг хэргийн ажилтан 1
Номын санч, бичиг хэргийн ажилтан 1
Нягтлан бодогч 1



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ СУЛ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ
(2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)



ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРТ
(73 сул ажлын байр)

Хүний их эмч 12
Хүүхдийн эмч 5
Дотрын их эмч 2
Уламжлалт анагаах ухааны эмч 3
Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч 2
Эмгэг судлаач эмч 1
Эмнэл зүйн эмгэг судлал 1
Дүрс оношилгооны их эмч 2
Нүдний эмч 1
Сэргээн засах эмч 2
Эмгэг судлалын ажилтан 1
Сүрьеэгийн эмч 1
Цус судлалын эмч 1
Чих, хамар хоолойн их эмч 1



Гэмтлийн их эмч 1
Хавдар судлалын их эмч 1
Өндөр настны эмч 1
Эрэгтэйчүүдийн эмч 1
Өсвөр насны хүүхдийн их эмч 1
Нийгмийн эрүүл мэндийн ажилтан 1
Багийн бага эмч 12
Сувилагч 20



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ СУЛ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)



**ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАРТ**
(24 сул ажлын байр)



Үйлчлэгч 3
Маркшейтер инженер 1
Ахлах тогооч 2
Туслах тогооч 1
Зөөгч 2
Галч 1
Сахиул 1
Нягтлан бологч, нярав 2
Худалдагч 4
Кассчин 2
Борлуулагч 3
Оёдолчин 1
Жолооч 1





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ СУЛ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

(2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)



**ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ
УДИРДАХ,
ГҮЙЦЭТГЭХ АЛБАН
ТУШААЛД
(58 сул ажлын байр)**

- Хайрхандулаан сумын НД-ын байцаагч
- Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны аудитор, улсын байцаагч
- БШУГ-ын Физик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
- БШУГ-ын Хөгжмийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
- Баянгол, Богд, Есөнзүйл, Өлзийт, Төгрөг сумын Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч
- Баруунбаян-Улаан, Баянгол, Бат-Өлзий, Гучин-Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Тарагт, Төгрөг, Хайрхандулаан, Уянга, Богд, Хужирт сумын Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч их эмч
- Бүрд сумын Газрын даамал
- Эрүүл мэндийн газрын Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Нарийнтээл сумын Баянтээг багийн Зохион байгуулагч

- Есөнзүйл сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Баянгол, Богд сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Есөнзүйл, Хужирт, Нарийнтээл сумын Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Баруунбаян-Улаан, Хархорин сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
- Төгрөг, Сант, Хужирт, Баруунбаян-Улаан, Тарагт, Арвайхээр сумын МAA-н асуудал хариуцсан мэргэжилтэн
- Сант, Баянгол, Богд сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
- Бүрд, Гучин-Ус, Есөнзүйл, Тарагт, Өлзийт, сумын Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хархорин сумын Соёл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн
- Хархорин, Нарийнтээл, Бат-Өлзий сумын байгаль хамгаалагч



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ СУЛ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар)



- Хужирт сумын Нийгмийн даатгалын тасгийн дарга бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч
- Аймгийн ЗДТГ-ын Төсвийн орлого, санхүүгийн зах зээл хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн ЗДТГ-ын Дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Аймгийн ЗДТГ-ын Цахим үйлчилгээ, бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Онги-Таац голын сав газрын захиргааны Усны барилга, байгууламж, үйлдвэр ХАА-н ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нарийнтээл сумын ЗДТГ-ын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
- Баруунбаян-Улаан сумын ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн

НИЙТ
216




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Улсын хэмжээнд суралцаж буй нийт оюутны 4 орчим хувийг тус аймгийн оюутнууд эзэлдэг бөгөөд сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харахад ЕБС-ийн нийт төгсөгчдийн 95 хувь нь их дээд сургуульд элсэн орж, жил бүр 1200 орчим оюутан төгсөж байна.

Оюутнууд, аймгийн хэмжээнд хамгийн их эрэлттэй байгаа хүний нарийн мэргэжлийн их эмч, ХАА-н мэргэжилтэн, экологич зэрэг мэргэжлээр төдийлөн бэлтгэгдэхгүй, хөдөлмөрийн зах зээлд илүүдэлтэй санхүүч, эрх зүйч мэргэжлээр түлхүү суралцаж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад жилд дунджаар 600 төгсөгч хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэн гарч байна. Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс харахад төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж 70 орчим хувьтай байна.





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.